

ХЯТАД ХЭЛНИЙ БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙХ ӨӨРИЙН УХАМСРЫН ТУХАЙ ӨГҮҮЛЭХҮЙ

Cui xiliang

Бээжингийн хэлний их сургууль

Товч агуулга: Энэхүү өгүүлэл нь 1. Хятад хэлний багш нар яагаад эрдэм шинжилгээний ажил хийх өөрийн ухамсартай байх хэрэгтэй вэ? 2. Хятад хэлний багш нар ямар ямар асуудлыг судлах ёстой вэ? 3. Хятад хэлний багш нарын эрдэм шинжилгээний ажил хийх өөрийн ухамсар гэдэг зүйлд юу юу багтаах вэ? гэсэн хятад хэлний багш нарын эрдэм шинжилгээний ажил хийх өөрийн ухамсрын асуудлын үүднээс 3 талаас авч бичсэн болно. Мөн танхимд сайн бүтээгч байхыг эрмэлзэгч гадна танхмаас гадуур сайн судлаач байхыг эрмэлзэгч байх хэрэгтэй гэж үзсэн байна.

Түлхүүр үг: Хятад хэлний багш, Эрдэм шинжилгээний ажил хийх өөрийн ухамсар, Мэргэжлийн карьераа төлөвлөх

Нэг. Асуудал дэвшүүлэх

БНХАУ-ын байр суурь өсөхийн хэрээр олон улсад нөлөөлөх хүчин зүйлс мөн төдий чинээ өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Энэхүү хүчин зүйлст улс төр, эдийн засаг, соёл, зэвсэгт хүчин, шинжлэх ухаан, техник технологи болон хэл гэх зэрэг олон зүйл багтана. Дэлхийн олон олон улс орон Күнзийн институт, Күнзийн танхим нээх, их дээд сургуулиуд хятад хэлний анги нээх зэргээр хятад хэл суралцагчдын эрэлт хэрэгцээг хангахын зэрэгцээ БНХАУ-д ирж суралцах хүмүүсийн тоо асар хурдацтай нэмэгдэж байна. Иймд гадаадын Күнзийн институт, танхим, их дээд сургуулиудын хятад хэлний тэнхим, БНХАУ-ын гадаад оюутан элсүүлэн авч буй их дээд сургууль болон бусад боловсролын байгууллагуудад хятад хэлний чадварлаг багш нэн тулгамдсан асуудал болж байна. Сүүлийн жилүүдэд бид бүхэн Күнзийн институтийн төвөөс зохион байгуулж буй хятад хэлний багш-сайн дурын багш нарын сургалтанд хамрагдахын зэрэгцээ хятад хэлний олон улсын боловсролын мэргэжлийн магистр судлаачийг бэлтгэх төслийг боловсруулсанаар гадаад суралцагчдад хятад хэл заах нь мэдлэг төдийгүй бидний бэлтгэж буй багш нар мэргэжлийн ёс суртахуун, чадамжтай байх ёстой гэдгийг гүн гүнзгий мэдэрлээ. Товч агуулга дээр дурдсан 3 асуулт нь логикийн харьцаа бүхий өнөөгийн нийгэмд бодит ач холбогдол бүхий асуултууд юм.

Хоёр. Хятад хэлний багш нар яагаад эрдэм шинжилгээний ажил хийх өөрийн ухамсартай байх хэрэгтэй вэ?

2.1 Сургалтын орчны олон талт өөрчлөлт багшид тавигдах сорил

Гадаад суралцагчдад хятад хэл заах сургалтаас авахуулаад хятад хэл нь олон улсын боловсролын түвшинд нэрээ солих төдий бус дотоод агуулгад өөрчлөлт гарсан. БНХАУ-д ирж суралцагчид болон өөрийн эх орондоо хятад хэл заах сургалт явуулах орчны хувьд харьцангуй ижил, сургалтын объект, зорилго, арга болон арга барилын хувьд харьцангуй тогтсон тодорхой байдаг. Өнөөгийн нөхцөлд томоохон өөрчлөлт бий болж сургалтын орчин, зорилго, суралцагчийн эрэл хэрэгцээ, сургалтын загвар, багш болон суралцагч хоорондын харилцаа зэрэг хүчин зүйлд өөрчлөлт хувирал бий болж олон талт хандлага бий болжээ. Манай багш нар өөр өөр сургалтын орчин, суралцагчтай тулгарах тул зохих ёсны бодлого баримталж эрэл хайгуул хийх хэрэгтэй.

2.1.1 Зорилтот хэл, эх хэлний тухай

БНХАУ-д ирж хятад хэл сурна гэдэг нь зорилтот хэлний орчинд сурахыг хэлж байгаа бөгөөд сургалтын төлөвлөлт, сургалтын материалын агуулга, хичээлийн төлөвлөгөө боловсруулах, танхмын сургалтын хэл, заах арга, сургалтын загвар нь бүгд нэлээдгүй туршлагыг хуримтлуулсны үндсэн дээр одоо бодитоор хэрэглэж буй арга барил, ур чадварыг бий болгосон. Улмаар энэхүү арга барил, ур чадвар, туршлага маань тухайн суралцагчийн эх хэлний орчинд төдийлөн нийцэж хэрэглэгдэхгүй болохыг анзаардаг. Суралцагчийн өөрийн улс орны сургалтын уламжлалт байдал, боловсролын талаарх үзэл баримтлал, сургалтын загвар, сургалтын зорилго, сургалтын шаардлага нь өөр өөр байх магадлалтай байдаг. Тухайлбал зарим улс орон суралцагчийн төрөлх хэлээр хятад хэл заах, анхан шатны суурь хятад хэлний сургалтанд зорилтот хэлийг хэтэрхий их хэрэглэхээс зайлсхийх тохиолдол байна. Харин бидний зорилтот хэлний орчинд суралцагчдын төрөлх хэлийг хэрэглэхгүйгээр хятад хэлээр сургалтаа явуулдаг. Зорилтот хэлний сургалтанд өнцөг булан бүрээс ирсэн өөр өөр хэл, соёлтой суралцагчид нэг ангид холилдон сурдаг. Тиймээс сургалтын явцад суралцагч бүрийг анхаарч тэдэнтэй тулж ажилладаг. Харин эх хэлээр явагддаг хятад хэл суралцагчид харьцангуй амар хялбар байхын зэрэгцээ тэдгээр суралцагчийн хэл, соёлын нөхцөл туйлын ойр байдаг. Зорилтот хэлний орчинд явуулж буй сургалт ямар нэгэн зүйлд хязгаарлагдахгүйгээр дасан зохицоод явагддаг бол эх хэлний орчны сургалт нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байдаг. Тиймээс байнга өөрчлөгдөхгүй сургалтын хэв загвараар бүхий л сургалтын үйл ажиллагаагаа зохион явуулдаг.

2.1.2 Суралцагчийн олон тал эрэлт хэрэгцээний өөрчлөлт

“Шавь”, “суралцагч” гэдэг ухагдахуун нь уламжлалт утгаар бол хоёрдагч хэл буюу хятад хэл суралцагчийг хамруулан ойлгож болохгүй, тэдгээр нь магадгүй бүхий л суралцагчийг заасан үг байж болно. Одоогийн хятад хэл суралцагчид дотор сурагч, оюутан, бага, дунд, их сургуулийн багш, профессор, компаний

менежер, ажилтан албан хаагч, гадаад харилцааны дарга, цэргийн хүн, гэрийн эзэгтэй, тэтгэвэрт гарагсад, хөгжимчин, үшү сонирхогч, соёл судлаач, шашны хүн, сэтгүүлч, шинжлэх ухаанч ер хэн байхыг үгүйсгэхгүй. Тэдгээрийн сурах хэрэгцээ шаардлага ч бас олон талаар илрэн гарч байна. Тухайлбал Maersk-ийн маркетингийн анги сонсгол, яриа зэргийг сурахыг шаардаж, унших, бичихийг чухалд тооцдоггүй. Хятад хэлний галигаар ханз үсгийг орлон хагас жилийн хугацаанд суралцагч бүрийг өдөр тутмын болон ажлын харилцааны түвшинд хүрсэн байхыг шаарддаг байна. Эдгээр хүн бол үүргийн шинжтэй “бичиг үсгийн балархай”, ханз үсэг танихгүй боловч харилцан ярианы чадвараа маш хурдацтай нэмэгдүүлж байдаг. Мөн жишээ татахад Харвардын номын хүрээлэнгийн оюутнууд Бээжинд очсоныхоо дараагаар “Онцгой шаардлагагүй тохиолдолд англи хэл хэрэглэхгүй гагцхүү хятад хэлээр харилцана. Эс бөгөөс нутаг буцаан сургалтын төлбөрийг нь буцаан олгохгүй.” гэсэн хэлний тангараг өгдөг. Энэхүү түргэвчилсэн дадлага нь багшид мөн адил шинэ шаардлага тавьж байгаа юм.

2.1.3 Суралцагчийн сэдэл, зовнил

Хятад хэл сурах сэдэл өөр өөр байх тул сурах хөдөлгөгч хүч бас адилгүй байна. Өмнөх үеийн судлаачид (Gao yande1993, Cui xiliang2000, Feng xiaoding 2003, Wang zhigang 2004, Xu qiuhan 2008) хятад хэл сурах сэдлийн талаар нэлээд их судалгааг хийсэн байна. Эдгээр судалгаагаас харахад БНХАУ-д суралцагчийн сурах сэдэл ч бас улам бүр олон цар хүрээг хамарч байна. Гадаад дахь хятад хэлний сургалтын нөхцөл байдал улам бүр нарийсч байгаа тул бид нарийвчлан дүн шинжилгээ хийж судлах шаардлага гарч байна. Суралцагчийн хувьд сургалтын явцад соёлын давхцал, сэтгэлзүйн зовнил зэрэг асуудлыг судлууштай. (Qian xunqing 1999, Shi renjuan 2005, Zhang li 2001, 2002, Zhang li, Wang feng2002).

2.1.4 Сургуулийн сургалт, чөлөөт сургалт

Хятад хэл сурах өөр өөр арга зам байдаг. Сургуулийн мэргэжлийн сургалт, нийтээр гадаад хэл сурах, чөлөөт цагаар сурах гэх зэрэг. (Тухайлбал интернет сүлжээг бие даан сурах, хувийн давтлага, гэрийн багш, хэлний хоцрогдол арилгах анги гэх мэт). Эдгээр сургалт нь өөр хоорондоо ижил болон ялгаатай тал бий. Стандартчилагдсан хэлний боловсрол нь төлөвлөгдсөн, явах ёстой зарчмаараа явагдаж байдаг бол чөлөөт сургалт нь харьцангуй дурын шинжтэй байдаг, тухайн хүнээсээ шалтгаалаад сургалтын үр дүн нь өөр байдаг. Зарим хүмүүс бар, кафе, чөлөөт зах руу очин бусадтай харилцан ярианы дасгал хийж хятад хэлний аялга үг, хар яриа сурдаг бөгөөд үгийн сангийн хувьд эмх замбараагүй, бүдүүлэг байдаг. Тэд яагаад танхмын орчинд суралгүйгээр бар, кафе гэсэн цэнгээний газар очдог юм бол? Энэ ч бас бидний судлах ёстой асуудлын нэг.

2.1.5 Глобалчлалын хандлага, соёлын олон талт зүйл

Глобалчлалын хандлагын хөгжил, соёл хоорондын харилцаа, сөргөлцөл, уусан шингэх үзэгдэл улам бүр газар авч, соёл иргэншил, хэл-соёл, нийгмийн тогтолцоо хоорондын харилцан яриа, ойлголцол хөгжих хандлагатай болж байна. Бид бүхэн танхмын сургалтын явцад өөр өөр үнэ цэнийг үзэх үзэл, өөр өөр соёлын үзэл, өөр өөр ажиглалтын өнцөг эсрэгцэх байдал бий болсоор байгаа ба энэхүү эсрэгцлийг хэрхэн зөөлрүүлэх талаар бид бүхэн судалж шинжлэх шаардлатай. Глобалчлал гэдэг нь нэгэн томоохон хандлага боловч дэлхийн бүх хүмүүс үүнийг таатай хүлээж авч байгаа гэсэн ойлголт биш. Соёлын олон талт шинж нь биологийн олон талт шинжтэй адил чухал боловч энэхүү ойлголтыг хүн бүр хүлээн зөвшөөрч байгаа гэсэн үг биш.

2.1.6 Сургалтын загвар, заах аргын солилцоо, нэгтгэх

Сургалтын загвар, заах аргын суурь нь өөр өөр хэлний заах аргын онол, хэлний сургалтын онол байдаг. Гадаад суралцагчдад хятад хэл заах сургалтын загвар, заах арга нь Энэтхэг, Европ хэлний заах аргын онолын нөлөөлөлд байдаг учраас тухайн язгуур хэлний сургалтын загвар, заах арга нь хятад хэлний сургалтад нийцэх албагүй энэ тал дээр хийсэн ач холбогдол бүхий судалгааны ажил ч гэсэн их байдаг. (Li juan 2007, Jiang liping 2008, Wu yongyi 2012, Chen feng 2010). Бидний хийсэн судалгааны ажил дийлэнхдээ барууны хэл заах аргын онолын хүрээнээс бүрэн ангижирч чадахгүй байгаа 3P, 5P сургалтын загварын хувьд зарчмын хувьд зөв боловч хятад хэл нь хоёрдагч хэлний заах аргын талаас хийсэн нарийн судалгааны ажил харин туйлын ховор байна. Сургалтын үзэл санааны солилцоо, уусан шингэх байдлыг хятад хэлний сургалтын загвар, заах аргыг багш нар маань илрүүлэн практик туршлага дээр үндэслэн үнэлж дүгнэх нь зүйтэй болов уу.

2.1.7 Орчин үеийн боловсролын арга барил хэлний сургалтанд нөлөөлөх нь

Бидний хэрэглэж, ашиглаж буй нөөц, мэдээллийн хэрэгсэл улам бүр боловсронгуй болж байгаа орчин үеийн боловсролын арга барилын хөгжилд төдий чинээ шаардлага тавигдаж байна. Тухайлбал мультимедиа технологи хэлний сургалтанд чухал үүрэг гүйцэтгэх нь (Zheng yanqun 2008, 2009) гэсэн судалгааны ажил одоо ямар үр дүнд хүрснийг судлах нь хэрэгтэй байна.

2.2 Олон ургалч онолын хятад хэлний сургалтын судалгаа

Хэлний сургалт бол нэгэн төрлийн практик шинжтэй сурган хүмүүжүүлэх үйлдэл юм. Энэхүү үйлдлийн цаана бүх төрлийн боловсролын онол багтаж байдаг. Өнөөгийн бидний мэдлэгийн хүрээний хувьд авч үзвэл хэл сурах нууц нь чухам юу вэ гэдгийг одоо болтол бодитоор тодорхойлох боломжгүй. Хүүхдийн хэл сурах чадвар яагаад насанд хүрсэн хүнээс илүү байдаг юм бол? Эмэгтэйчүүдийн хэлний чадвар яагаад эрчүүдийхээс илүү давамгайлсан байдаг юм бол? Хэлийг аяндаа

сурах уу эсвэл хичээл сургалтаар сурах уу? Анхдагч хэлний чадвар, хоёрдагч хэлний чадвар адил уу? Бидний их тархинд хэл сурах төрөлхийн механизм оршин байдаг уу? Хэлийг сурах явцад эх хэлний нөлөө хэр их байдаг вэ? Эх хэлний сөрөг нөлөөг хэрхэн даван туулах вэ? Ижил танхмын орчинд сурсан атал сурлагын дүн яагаад хол зөрүүтэй байдаг вэ? Хятад хэл болон бусад хэлийг судлахдаа ижил зарчим баримтлах эсэх? гэх мэт. Өөр өөр хүсэл мөрөөдөл хятад хэлний багшийн сонголтыг шийдвэрлэх эсэх, тухайлбал заан сургах төвт үү эсвэл сурах, судлах төвт үү? Заан сургах төвт бол хэрхэн хийх ёстой вэ? Сурах, судлах төвт бол хэрхэн хийх ёстой вэ? Олон ургалч онолын цаана олон төрлийн үзэл суртал эргэлдэн байна. Хэрэв манай хятад хэлний багш нар эрдэм шинжилгээний ажил хийх өөрийн ухамсар, онолын бэлтгэлгүй бол зүг чигээ олохгүй амархан төөрөлдөх болно.

2.2.1 Хэлний сургалтанд соёлын асуудлыг хөндөх тухайд

Энэхүү онол нь Англи хэл хоёрдагч хэлний сургалт болох нь онолоос эхлэлтэй, үүнээс хойш гадаад суралцагчдад хятад хэл заах сургалтын явцад соёлын асуудлыг дэвшүүлэн тавьж байсан. (Zhao shenzhou 1989, Wei chunmu, Kajuefei 1992, Lu bisong 1992, Fengxue 2010). Хожим АНУ-ын соёл төвт хятад хэлний сургалтын загварыг тусгайлан судалсан байдаг бөгөөд гагцхүү соёл бус бусад асуудлыг хөндсөн байсан (Xielingling 2012). Хэлний сургалтанд соёлын асуудлыг хэрхэн шийдэх нь судлууртай асуудлын нэг юм. Соёлын асуудлыг татан оруулах, соёлоор тэргүүлэх, эсвэл соёлын ялгаа, соёлын хүчин зүйлийг анхаарах уу? Хэл,соёл 2 салшгүй холбоотой, хэл бол соёлын тээгч. Гэхдээ хэлний сургалтанд хэл голлох уу, соёл голлох уу гэдэг нь огт өөр үзэл санаа юм. Үүний үр дүнг хятад хэлний багш нар судалгаа шинжилгээгээр илрүүлэх юм.

2.2.2 Асуудалд тулгуурлах, онолд тулгуурлах

Эрдэм шинжилгээний судалгааны зорилго нь үзэгдлийг ойлгон, асуудлыг шийдвэрлэх байдаг тул аливаа онол асуудалд тулгуурласан, ажигласан, задлан шинжилсэн, тайлбарласны үндсэн дээр тавигддаг байх хэрэгтэй. Хоёрдагч хэл буюу хятад хэлний сургалтын судалгаа нь асуудлаас үүдэн гарсан, асуудалд хөтлөгдсөн судалгаа байх ёстой (Cui xiliang 2011). Эхлээд онол, эхлээд асуудал гэдэг тал дээр одоо хүртэл мэтгэлцдэг, хятад хэлний багш нарын хувьд бидний бүхий л асуудал сургалтын практикаас гарч ирсэн байдаг тул бидний судалгаа бол бодит асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байдаг гэдгийг хэлэх гэсэн юм. Асуудлыг шийдвэрлэж чадаж байвал онол тийм ч шаардлагагүй. Онолын үзэл баримтлалаас шалтгаалаад бидний харах өнцөг ч бас өөр байна. Асуудлаас урган гарсан онол байвал туйлын сайн байх болно.

2.2.3 Хэл шинжлэлийн судалгаа болон боловсрол судлалын судалгаа

Хоёрдагч хэл буюу хятад хэлний сургалт нь 1. Хятад хэл, 2. Хэл, 3. Заах арга гэсэн 3 түлхүүр үгтэй байна. Энэхүү хүрээнд бидэнд тулгарч буй асуудал хэл шинжлэлийн асуудал байж болох мөн боловсрол судлалын асуудал байж болох юм. Энэхүү судлагдахууны шинж чанар тодорхой болсон, олон судлагдахуун огтлолцсон, практик шинжтэй онцлог давамгайлсан байдаг. Хятад хэлний асуудал хэл шинжлэлийн асуудалд хамаарагддаг, заах аргын асуудал боловсрол судлалын асуудалд хамаарагддаг, хэл сурах асуудал нь хэл шинжлэл болон танин мэдэхүйн сэтгэл судлалын ухаанд хамаарагддаг юм.

2.2.4 Заан сургалтаар судалгаа явуулах, судалгаа шинжилгээгээр сургалтаа явуулах

Бид бүхэн сургалтаар дамжуулан эрдэм шинжилгээний судалгаагаа явуулахыг уриалдаг. Эхлээд сургалт явуулж дадлагажуулсны дараагаар сая судалгаа явуулах асуудалтай болж ирдэг. Мөн бид эрдэм шинжилгээний судалгаагаар дамжуулан сургалтаа явуулж сургалтын чанараа дээшлүүлэхийг уриалдаг. Эрдэм шинжилгээ судалгааны саадгүй сургалт ямар ч итгэл төрүүлэхүйц байж чадахгүй. Эрдэм шинжилгээний судалгаанд суурь онолын судалгаа, хэрэглээний судалгаа багтах боловч үүрэг, зорилго нь өөр өөр байна. Үүрэг нь онолын бүтцийг бий болгоход анхаардаг бол зорилго нь сургалт практикт тулгарсан бүхий л асуудлыг шийдвэрлэхэд анхаардаг. Дээрх хоёр зүйл тохирсон оролтоо олох болно гэж найдаж байна (Cui xiliang 2003).

2.2.5 Олон судлагдахууны огтлолцол, дан судлагдахуун уусах

Гадаад суралцагчдад хятад хэл заах сургалт нь нэгэн төрлийн огтлолцсон судлагдахуун, түүний агуулга нь хэл шинжлэл, боловсрол судлал, танин мэдэхүйн судлагдахуун, мэдээлэл зүйтэй шууд холбогддог. Эрдэм шинжилгээний судалгааны өнцгөөс харахад олон судлагдахууны огтлолцлын судалгаа нь маш олон асуудлыг шийдэж болох учраас өөр өөр салбарын судлаачдын хамтын ажиллагааны судалгаа нэн шаардлагатай байгаа юм. Хятад хэлний багш нарын эх үүсвэр олон талтай байдаг, тухайлбал тэдний судалгааны бүтэц, судлагдахууны бүтэц олон талтай байдаг тул тал бүрийн шинжлэх ухааныг хамарсан хамтарсан судалгааны ажлыг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Түүний зэрэгцээ дан судлагдахууны талаар нарийвчилсан судалгаа хийж болох юм.

2.2.6 Бүтэц хэл шинжлэлийн судалгаа болон үүргийн хэл шинжлэлийн судалгаа

Өнөөгийн байдлаар хэл шинжлэлийн 2 том урсгал байдаг ба хэлбэрийн ба үүргийн хэл шинжлэл гэж хуваана. Тэдний гүн ухаан, хэлний үзэл баримтлал, судалгааны загвар нь бүгд өөр байдаг. Энэхүү 2 том урсгал гадаад суралцагчдад хятад хэлний заах судалгаанд илэрч гарсан байдаг. Хоёрдагч хэлийг сурах судалгааны онолын таамаглал нь хэлбэрийн хэл шинжлэлд хамаарагддаг бөгөөд

бидний сургалтанд ашигладаг хэлзүйн судалгааны онолын нөхцөл нь үүргийн хэл шинжлэлд багтдаг.

3. Хятад хэлний багш ямар асуудал судлах ёстой вэ

Онолын талаас авч үзвэл хятад хэлний багш нь ямар ч асуудлыг судалж болох учраас тэдний сургалтын практик явцад суралцагчид маш олон төрлийн асуултыг багшаасаа асуудаг. Тухайлбал: улс төр, эдийн засаг, соёл, түүх, нийгэм, шашин, урлаг, онолын цаашилбал нэвтэрхий толины асуултыг асуудаг тул эдгээрийг судлах хэрэгтэй. Мэргэжлийн багш тухайн шинжлэх ухаанд нэвтэрхий байхаас гадна хэлний багшид түгээмэл тулгардаг асуудал бол хятад хэл тэр дундаа сургалтын чанар, үр бүтээмжийг хэрхэн дээшлүүлэх байдаг.

Тухайн хэлний өөрийн онцлог, бүтэц зүй тогтлыг ойлгох нь сургалтын суурь байдаг тул энэхүү суурийг ойлгосны үндсэн дээр бусад зүйлийг ойлгох боломжтой. Харин хэрхэн заах тал дээр бол аргын онолтой холбогдон, хэлний заах аргатай шууд холбогддог. Хэлний заах аргын цаана сургалтын онол, үзэл баримтлал байдаг ямар ч аргаар сургалтыг явуулах боломжтой боловч аль нэгийг нь сонговол хамгийн сайн гэсэн юм байхгүй. Бүх арга л өөр өөрийн гэсэн давуу талтай тул хэрхэн сонгохоос сургалтын материал, объект, агуулга, орчин зэрэг хүчин зүйлийг бодолцохоос гадна хэлний дотоод хүчин зүйлийг бодолцож үзэх шаардлагатай. Ихэвчлэн суралцагчдын танин мэдэх үйл явцтай шууд холбогддог. Сурлагын амжилт мөн олон хүчин зүйлтэй холбоотой, тухайлбал сурах сэдэл, сурах арга, суралцагчдын туршлага, суралцагчдын сэтгэлзүйн тогтвортой байдал, суралцагчдын сурах чадвар гэх зэрэг, эдгээрийг танин мэдэхүйн өнцгөөс харж судлах нь зүйтэй.

Хоёрдагч хэлний сургалт буюу хятад хэлний судалгаа нь олон талыг хамарч болно. Тухайлбал авиазүй, хэлзүй, ханз, үгийн сан, найруулга зүй, бичгийн хэлний судалгаа, хэлний хэрэглээний судалгаа гэх мэт. Үүнд дотор нь өөр өөр дэд сэдвүүдэд хувааж болно. Жишээ нь авиазүйн судалгааг Гадаад суралцагчдад хятад хэлийг заах судалгаа нь хятад хэлний өөрийн судалгаагаас өөр байдаг нь дараах хэдэн байдлаар илэрнэ.

1. Судалгааны зорилго өөр байна. Хятад хэлний уг судалгаа нь хэлний дотоод зүй тогтлыг дүрсэлж бичихэд анхаарч хэлний бүхий л нарийн үзэгдлийг тайлбарлаж, хэл хувьсах түүхэн замналыг тогтоох, хэлний дотоод зүй тогтлын онолын загварыг бий болгох асуудлууд байдаг. Харин гадаад суралцагчдад хятад хэлийг заан сургах үйлийн судалгаа нь хэлний дотоод зүй тогтлыг тодорхой дүрслэхийн зэрэгцээ суралцагчдад хэрхэн хялбар байдлаар ойлгуулж, эзэмшүүлэх талаар бодолцож үзэх хэрэгтэй байдаг.

2. Судалгааны асуудал нь өөр байна. Хятад хэлний уг судалгаа нь сэдэв сонголтын хувьд харьцангуй өргөн далайцтай байдаг тул хятад хэлтэй холбоотой бүхий л асуудлыг судлаачид авч судалж байдаг. Харин гадаад суралцагчдад хятад хэлийг заан сургах үйлийн судалгаа нь сургалтын явцад суралцагчдад тулгарч буй бэрхшээлийг судалдаг тул зарим тохиолдолд хэлний судлаачид анхаарахгүй байх тохиолдол байна. Тухайлбал суралцагч “Хятад хэлний тооллого үг хэрэглээний ямар зүй тогтолтой байдаг вэ?” “1 жил”, “1 долоо хоног”, “1 өдөр”, “1 цаг”, “1 минут”, “1 секунд” гэх зэргийг тооллого үг аван хэлж болох боловч “一个年”、“一个分钟” гэж хэлж болохгүй. Яагаад? Хятад хэлний дотоод асуудлыг судалдаг судлаачид энэхүү асуудлыг анхаарч чадахгүй, харин хоёрдагч хэлний сургалт нь ийм төрлийн асуудлаас зайлшгүй байдаг.
3. Судалгааны цөм нь өөр байдаг. Хятад хэлний уг судалгааны гол цөм нь хэлэнд өөрт нь байдаг. Хоёрдагч хэлний сургалтын судалгааны гол цөм нь заах аргадаа байдаг. Жишээ нь “的” хэрэглэхгүй байх асуудал. Миний аав, миний ээж гэдгийг “我的爸爸”、“我的妈妈” гэж хэлж болох боловч “我的狗”、“我的猫” гэдгийг “我狗”、“我猫” гэж хэлж болохгүй. Яагаад? Хятад хэлний судлаачид гүн давхаргын танин мэдэхүйн сэдлийг олж хараасай гэж эрмэлздэг. Zhangmin (1998) когнитив хэл шинжлэлийн “Зайн дүрслэлийн шинж”-ээр энэхүү зэгдлийг тайлбарлана. Харин хоёрдагч хэлний сургалтын судалгаа нь яаж тайлбарлавал суралцагчид хурдан ойлгох вэ гэдэг асуудлыг бодолцох хэрэгтэй. Жишээ нь Cui xiliang (1992b) хамаарлын харьцааны “Чөлөөтэй шилжихүйц шинж” – ээр энэхүү асуудлыг тайлбарлаж болно. “Нохой”, “муур” бол бусдад шилжүүлж, дамжуулж болохуйц зүйл боловч “аав”, “ээж” –ийг бусдад шилжүүлж болохгүй.

3.1 Авиазүйн асуудал

Авиазүй сурна гэдэг нь хэл сурах анхны алхам болдог. Аливаа хэлний авиазүйн тогтолцоо нь өөр байдаг. Өөрийн эх хэлний авиазүйн тогтолцоог хэрэглэж хэвшээд сурчихсан байдаг тул хоёрдагч хэлийг суралцах явцдаа эх хэл хүчтэй нөлөөлдөг бид энэхүү үзэгдлийг эх хэлний нөлөө гэж нэрлэдэг. Хятад хэлний авиазүйн тогтолцоо харьцангуй гайгүй байдаг, зарим хүмүүс хятад хэлний авиазүйг маш хэцүү гэж ярьдаг. Эх хэл нь япон хэлтэй суралцагчид нийлмэл гийгүүлэгч болох zh, sh, ch, r болон уруулын эгшиг [u] авиаг сурахад хэцүү гэж үздэг. Харин солонгос суралцагчид zh, sh, ch, r гийгүүлэгчээс гадна [f] авиаг сурахад хэцүү гэж үздэг байна. Авиазүйн судалгаа, хятад хэлний авиазүйн судалгааны талаар Wang jia (2008) маш дэлгэрэнгүй судалгаа хийсэн байдаг. Авиазүйн асуудлыг ерөнхийд нь дараах хэдэн айд хуваан авч үзэж болно.

3.1.1. Нийлмэл гийгүүлэгчийн тухай

Хятад хэлний нийлмэл гийгүүлэгчийн тогтолцоонд сурахад хамгийн хэцүү авиа бол zh, sh, ch, r, j, q, x байдаг. Бусад гийгүүлэгчийн хувьд тухайн хэл хэлэнд байдаг тул сурахад харьцангуй гайгүй байдаг. Зарим суралцагчийн хувьд эх хэл, зорилтот хэлний хоорондын ялимгүй зөрүүг анзааралгүйгээр өөрийн хэлэнд байх авианаасаа z, c, s-тай адил дуудлагатай авиаг олоод хэлээд сурчихдаг. Англи хэлний хэлний авиа болох [ʃ] [ʒ] [ʒ] хятад хэлэнд байдаггүй харин англи хэлээр ярьдаг хүмүүс хятад хэлний zh, sh, ch авиаг англи хэлний хэлний авиатай амархан хольж хутгадаг.

3.1.2. Эгшгийн тухай

Хятад хэлний дан эгшиг харьцангуй цөөн байдаг тул сурахад амаргүй байдаг. Гэхдээ дан эгшийн байрлал өөр өөр хэлний орчинд хувьсан өөрчлөгддөг энэ зүйлийг анхаарч судлууштай. Тухайлбал хятад хэлний [i] өөр авиатай хамт орвол тухайн авианы хэлэгдэх дуудлага харьцангуй ялгаатай болдог. z, c, s, zh, sh, ch, r, j, q, x гэсэн гийгүүлэгчтэй хамт орж хэлэгддэг бөгөөд суралцагчид “老师” [lǎoʃi] энэ нь хятад хэлний галигтай хольж хэрэглэж байгаагийн нэг жишээ юм. ia авиа доторх “i”, ai доторх “i” үнэндээ 1 авиа биш юм. Эс бөгөөс “我爱你” гэдэг үг нь “我阿姨你” гэж сонсогдоно. ü нь бас л дуудахад төвөгтэй авианы нэг, ихэнх хүн “女人” гэдгийг “努人” болгож хэлдэг.

3.1.3. Холимог эгшгийн тухай

Зарим суралцагчийн хувьд ia, ui, ian, uan, üan ai, uai, ei, uei, ao, iao, ou, iou, iang, uang, uen, üen зэрэг авиа нь маш хэцүүхэн бэрхшээл болдог. Суралцагчид авиан байрлалын тухай, авиа солигддог тухай ямар нэгэн тодорхой ойлголтгүй бол дуудахад эндүүрэл гарах тохиолдол байна. Жишээ нь uai (歪) -ийг u→a→i (吴阿姨) гэж хэлэх магадлалтай.

3.1.4. Хөгийн тухай

Дэлхий дээр 5000 гаруй хэл байдаг бөгөөд хөгтэй хэл цөөнх хувийг эзэлдэг гэсэн судалгаа бий. Нэг үеийн хөгийн хувирлаас үүдэн өөр өөр ялгаатай утгыг илэрхийлдэг. Хэрэв суралцагчийн эх хэл нь хөгтэй бол тухайлбал Вьетнам хэл бол хятад хэл сурахад тийм ч хэцүү биш байна. Хэрэв суралцагчийн эх хэл нь хөггүй тухайлбал англи хэл байвал хятад хэлний хөг сурна гэдэг томоохон сорил болдог. Тэдгээрт хөгийг хэрхэн заах талаар эрдэмтэн судлаачид олон төрлийн арга зохиосон боловч төдийлөн үр дүнд хүрээгүй. Жишээ нь Zhao yuangen хятадын 5 шулуунаар хятад хэлний 4 хөгийг тэмдэглэн харуулсан нь нээлт болсон боловч сөрөг нөлөө нь хамгийн дээд авиа гаргах хэлбэр гэж ойлгосонтой холбоотой байдаг. Үүнээс гадна хөгийн өөрчлөлтийн асуудал байдаг. “你好” гэдгийг “尼好”, “美好” гэдгийг “梅好”, “野百合” гэдгийг “爷百

合” уншиж хэлвэл зохистой. Эдгээр нь суралцагчдын хувьд асуудал, бэрхшээл болдог тул хэрхэн зөв оновчтой хятад хэлний хөгийг эзэмшүүлэх нь судлууртай асуудал болдог.

3.1.5. Аялгын тухай

“你姓李，我姓汪” гэсэн өгүүлбэрийг энэтхэг европ хэлтэй хүмүүс “你姓黎，我姓望” гэж хэлдэг. Энэхүү аялгын асуудал нь өнөөг хүртэл хятад хэлний багш нарын хувьд маш бэрхшээлтэй байдаг. Аливаа хэлэнд өөрийн гэсэн аялгын хэлбэр байдаг бөгөөд зорилтот хэлний аялгын мэдрэмжид нөлөөлж байдаг. Ялангуяа хөг, аялгыг сурна гэдэг дийлэнх суралцагч маш төвөгтэй санагддаг.

3.1.6. Хөнгөн хөг, 儿化 тухай

Баримжаа аялгууны хөнгөн хөг, 儿化 бол хятад хэл суралцагчдын хувьд бас нэг асуудал болдог. “地道” ба “地·道” -ийн утга өөр, “运气” “运·气” мөн утга өөр. “前门” болон “前门儿” нэг газрыг заахгүй. Гадаад болон бусад нутгийн аялгатай хүмүүсийн хувьд хөнгөн хөгийн тухай нэг бүрчлэн суралцах хэрэгтэй. Хамгийн хэцүү бэрхшээл бол 儿化 тухай. “西便门儿” -ийг 儿化 -тай хэлж болдог мөртөө “德胜门” “天安门” зэргийг 儿化 -тай хэлж болохгүй гэж? “小张儿”, “小王儿” -ийг 儿化 -тай хэлж болдог мөртөө “小崔” “小魏” зэргийг 儿化 -тай хэлж болохгүй гэж? “小张儿” -ийг 儿化 -тай хэлж болдог мөртөө “老张” -ийг 儿化 -тай хэлж болохгүй гэж? “盆” ба “盆儿” гэсэн 2 хэлбэр бүгд байдаг. 儿化 авах, авахгүй байх ямар ялгаатай гэж? “哥们儿” үү? “哥儿们” үү? “没门” ба “没门儿” нь ямар ч төстэй ижил утгагүй үгүүд юм.

3.2 Хэлзүйн асуудал

Бид бүхэн өөрсдийн эх хэлний тухайд тодорхой зарчмын дагуу хэлний нэгж бүр бүрэлддэг гэдгийг анзаараагүй байж болох талтай ч гадаад хэлийг сурах явцад завсрын хэлний үзэгдлээс хэлзүйн дүрэм оршин байдгийг мэдэж авдаг. Доор хятад хэлний завсрын хэлний жишээг танилцуулья. (Cui xiliang 2009)

1. 我们一起过的时间很好。
2. 在公共汽车上不给女让座。
3. 这个问题我想出不来。
4. 他天天津津有味地听音乐，恐怕没有音乐的话他没法生下来。
5. 小二黑在谈恋爱的时候，只好看一看小二黑的对象的命。
6. 他身体越来越康复一点儿。
7. 我的个子比他的个子不高。

Хэрэв хангалттай хэлний орчин байгаа бол хятад хүмүүсийн хувьд дээрх

өгүүлбэрүүд ойлгоход тийм ч хэцүү биш боловч бидэнд эвгүй санагдаж байгаа нь дээрх өгүүлбэрүүд хятад хэлний хэлзүйн дүрэмд нийцэхгүй байгаа юм. Гадаад суралцагчдад хятад хэл заах сургалтанд нэлээд олон хэлзүйн асуудлууд байдаг бөгөөд судлаачид ч олон байдаг. Хэвлэгдсэн бүтээл, нийтлүүлсэн өгүүлэл ч бас олон бий. (Shao jingmin 2011), Zhang bin “ОЦХХ-ний хэлзүй” 2010 бүтээлд хятад хэлний хэлзүйн бүхий л асуудлыг хөндсөн байдаг. Үүний зэрэгцээ шийдвэрлүүштэй маш олон асуудлууд байна. Тухайлбал хятад хэлний үгийн дарааллын тухай, хятад хэлний гадаад байдал, хятад хэлний байдлын тухай, үгсийн аймаг, өгүүлбэрзүй, хэлзүйн онцлог, өгүүлбэр дэх хэмнэл зэрэг асуудлыг судлах хэрэгтэй байна. Үүнээс гадна үйл үгийн давталт, онцгой бүтцэт өгүүлбэр болох “被动句”, “把”字句, 比字句, 疑问句, 连动句, үйл үгийг хуулбарлах, мэдээлэл дамжуулах арга хэрэгсэл, тооллого үгийн хэрэглээний зарчим зэргийг судлууштай.

3.1.2 Үгийн дарааллын тухай

Үгийн дараалал гэдэг нь өгүүлбэрийн гишүүн өгүүлбэрт байрлах дэс дарааллыг хэлнэ. Жишээ нь:

- | | |
|----------------|-----------------|
| 8. 不怕辣~辣不怕~怕不辣 | 又大又圆的苹果~又圆又大的苹果 |
| 他有女朋友了~他女朋友有了 | 大圆脸~ * 圆大脸 |
| 你不理财~财不理你 | 语言研究所~ * 研究语言所 |
| 来客人了~客人来了 | 煤炭开采权~ * 开采煤炭权 |
| 在北京住~住在北京 | 食品加工厂~ * 加工食品厂 |

Дээрх жишээнүүд бүгд хятад хэлний үгийн дараалалтай холбоотой асуудлууд юм. Эгнээ бүхий жишээ нь өөр өөр утга илэрхийлнэ. Бид бүгд хятад хэл хэлбэрийн хувиралгүй хэл гэдгийг мэдэх учраас үгийн дарааллын хувирал гэдэг нь хэлзүйн гол хэрэгсэл юм. Чухам ямар зүйл хятад хэлний үгийн дарааллыг хязгаарлаж байна вэ? Хуулийн нэр томъёо болох “走私毒品罪” “毒品走私罪” аль нь дээр вэ? Яагаад? Энэ ч мөн судлууштай асуудлын нэг юм.

3.2.2 Хятад хэлний гадаад асуудлын тухай

Үйл явдлын цаг хугацааны хамаарлын хэлзүйн ай цаг, хэв байх бөгөөд эдгээр нь хятад хэлний хэлзүйн хүрээнд гаднах төлөвийн асуудал гэж нэрлэгддэг. Хэлбэргүй хэл тул үгийн сангийн аргаар цагийг илэрхийлдэг. “-了、-着、-过、-来着、-着呢” хятад хэлний цагийн ухагдахууныг илэрхийлдэг хэлзүйн хэлбэр гэгддэг боловч хэлзүйн утгагүй юм. Ялангуяа “了” -ийн асуудлыг яг ямар үед хэрэглэх шаардлагатай, ямар үед хэрэглэхгүй “了1” ба “了2” ямар холбоотой болох талаар одоо болтол тодорхойгүй байна. Тиймээс суралцагчид хэрэглээний явцад байнга алдаа гаргаж байдаг. “了” -ийн хэрэглээ маш этгээд тул багш нь үүргийг судлаад тодорхой зааж ойлгуулах хэрэгтэй. Дараах өгүүлбэр утгын хувьд ямар

ялгаатай байна вэ?

9. a. 这本书我看十天了。 b. 这本书我看了十天了。 c. 这本书我看了十天了。

9a жишээний утга нь хараахан уншиж дуусаагүй байгааг илэрхийлэх ба “了” нь “看” гэсэн үйлийн үргэлжилж байгаа санааг илэрхийлнэ. 9b жишээний утга нь уншаад дуусчихсан гэсэн санааг илэрхийлнэ. “了” нь “看” гэсэн үйлийн үргэлжилж байгаа санааг илэрхийлнэ. 9c жишээ нь их зөрчилдөөнтэй байдаг. Утгын хувьд “看” гэсэн үйл нь “十天” үргэлжилсэн болох талтай ч дуусаагүй байх утгыг илэрхийлж ч болно. Мөн түүнчлэн “看” гэсэн үйл нь дууссаны дараах цаг хугацаа нь “十天” байж болох юм.

3.2.3 Хятад хэлний баймжийн тухай

Баймж нь өгүүлбэрзүй болон утгын чухал ай юм. Баймжийг хэл хэлэнд өөр өөр арга хэрэгслээр илэрхийлдэг. Хятад хэлэнд баймж илэрхийлэх хэлзүйн арга байдаг. Жишээ нь “啊、吧、呢、嘛、哈、哦、啦” гэх мэт.

10. 明年去上海看你啊!	明年去上海看你哈!
明年去上海看你吧!	明年去上海看你哦!
明年去上海看你呗!	明年去上海看你啦!
明年去上海看你嘛!	

Аялга үгийн илэрхийлэх утга нь ч өөр байна. Энэхүү өөр өөр утга бүхий аялгыг /баймж утга/ хэрхэн ялгаж салгах нь маш төвөгтэй. Ялангуяа эх хэлэнд нь ийм баймж утга илэрхийлэх арга хэрэгсэл байхгүй бол аялга үгийг эзэмшиж авахад хэцүү байх болно.

3.2.4 Хятад хэлний үгсийн сангийн тухай

Үгийг хэлзүйн ангилал, нөхцөл, стандартын дагуу ангилан хуваасныг үгсийн сан гэж үзнэ. Энэтхэг, европ хэлэнд үгсийн аймгийг харьцангуй хялбар байдлаар хуваан авч үздэг. Жишээ нь нэр үг нь тоо, тийн ялгал гэсэн хэлзүйн айтай, үйл үг нь цаг, хэв, байдал, тэмдэг нэр ч мөн адил ийм хэлзүйн тэмдэгтэй байхад хятад хэлэнд байхгүй. Энэтхэг, европ хэлэнд үгсийн аймаг, өгүүлбэрийн гишүүн зохицох харьцаа, өгүүлбэрийн гишүүн хооронд нэгдмэл харьцаатай байхад хятад хэлэнд эдгээр нь байхгүй. Хятад хэл суралцаж буй хүмүүс хятад хэлийг дүрэмгүй, хэлзүйгүй хэл гэж боддог. Мэдээж хэлзүйтэй боловч бусад залгамал хэлээс өөр. Хятад хэлний үг хаана байрлахаас шалтгаалан үгсийн аймгийг тодорхойлж болно. Мөн нийлэмжийг үндэслэн үгсийг ангилдаг. Үгсийн аймгийг ойлгосноор нийлэмжийн зарчмыг ойлгож болно.

3.2.5 Хятад хэлний өгүүлбэрийн хэлбэрийн тухай

Хятад хэлэнд зарим нэгэн онцгой бүтэцтэй өгүүлбэр байх бөгөөд үүнд “把” 字

句, “被”字句, “连”字句, 比较句, “得”字句, “有”字句, “是”字句, 存现句, 双宾语句, 连动句 гэх мэт. 连动句-ээр жишээ авахад хятад хэлний 1 өгүүлбэрт хэд хэдэн үйл үг зэрэгцэн орж болохын зэрэгцээ үйл үгийг өөрчлөх шаардлагагүй байдаг.

11. 老师派我开车进城找小王去买电影票。

Энэтхэг, европ хэлэнд 1 өгүүлбэрт ганц л үйл үг байдаг хэрэв орсон тохиолдолд гол үйл үгээс гаднах үйл үг нь үгийг хуваах хэлбэрээр эсвэл ямар нэгэн хэлбэргүйгээр илэрдэг байна. Дээрх онцгой бүтцэт өгүүлбэрийн талаар судалгаа хийсэн судлаачид нэлээд их байдаг ба олон нийтлэл, өгүүлэл хэвлүүлж гаргасан байдаг.

3.2.6 Хятад хэлний хэлзүйн онцлогийн тухай

Дэлхий дээр 5000 гаруй төрлийн хэл байхад бид зөвхөн мэддэг хэдэн хэлнийхээ хүрээнд харьцуулал, зэрэгцүүлэл хийж болохгүй. Тухайлбал бид өмнө нь япон, солонгос, европ, америкийн суралцагчдын угтвар үг сурч буй тал дээр тусгайлан судалгаа явуулсан бөгөөд завсрын хэлний угтвар үг сурах тал дээр ихээхэн ялгаатай байгааг олж мэдсэн бөгөөд энэхүү ялгаа нь эх хэлтэйгээ харьцуулсны үндсэн дээр тайлбарлагдаж байсан. (Cui xiliang 2010b) Бид хятад хэлний хэлзүйн онцлогийг маш бага ярьдаг. Хэрэв үнэхээр хятад хэлний онцлогийг олж чадвал тэрхүү судлаачид баяр хүргэх болно.

3.2.7 Хэлзүйн бусад асуудал

Суралцагчдын хамгийн их асуудаг асуулт бол яагаад үүнийг ингэж хэлж болж байхад түүнийг ингэж хэлж болохгүй гэж гэсэн асуулт байдаг. Жишээ нь:

12. 视觉~视力	触觉~ * 触力
听觉~听力	嗅觉~ * 嗅力

Хятад хэлэнд их хэмжээний зэрэгцсэн хос дуудлагатай үг байдаг. АВ хэлбэр бүхий зэрэгцсэн хос дуудлагатай үгийг ВА гэж хэлэх нь зөв.

13. 桌椅~ * 椅桌	道路~ * 路道
男女~ * 女男	头脑~ * 脑头
领袖~ * 袖领	耳目~ * 目耳

Яагаад? Ямар зүй тогтол байна? (Cui xiliang 1991) “房屋” гэдэг нь зэрэгцсэн бүтэцтэй хос дуудлагатай үг юм. Суралцагчид “屋” ба “房” -ийг ялгаагүй хэмээн бодоод “同屋” -ийг “同房”, “茅房” -ийг “茅屋” гэж эндүүрч хэлж болзошгүй.

“茅房”，“茅屋” ямар ялгаатай талаар асуувал “松花蛋” ба “松花江” ялгааг бодож хэлнэ гэж боддог.

3.3 Хэл найруулгын тухай

Хятад хэлний бичлэгийн бүтэц дотроо өөрийн гэсэн зүй тогтолтой. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд цөөнх хүн энэхүү зүй тогтлын талаар бичсэн байдаг. Chen chen (2010a, 2010b) англи хэлээр ярьдаг суралцагчдын завсрын хэлний бичлэгт судалгаа хийж тулгардаг түгээмэл алдааг олж харсан нь маш үнэтэй бүтээл болсон юм. Хэл найруулгын холбоос, залгаа, товчлол, холбоо хамаарал зэрэг өгүүлбэрзүй, утгын арга барилтай шууд холбогддог. Суралцагчдын найруулгын гол бүтэц нь нэг л биш байдаг боловч яг ямар газар гэдгийг тэр дороо хэлж мэддэггүй. Дараах зохион бичлэгийг харья.

Энэхүү зохион бичлэгт найруулгын анализ хийлгүйгээр жишээ болгон харуулсан ба суралцагчдын хятад хэлний зохион бичлэг, найруулгын тал дээр нэлээд асуудал байгааг харж болно. Аман болон бичгийн хэл нь нэлээд ялгаатай тул хэрхэн оновчтой бичгийн хэлийг сонгон хэрэглэх нь маш чухал боловч энэ нь маш том сорил гэдгийг бид мэдэж байгаа.

3.4 Ханзны тухай

Галиг үсэгтэй суралцагчдын хувьд ханз нь ойлгомжгүй тэмдэгт тогтолцоо бөгөөд сурахад хэцүү байдаг. Ханз үсэг сургах хамгийн үр дүнтэй бодлого юу вэ? Хятад хэлний бүхий л багш нарын хувьд санаа зовоосон асуудлын нэг байдаг (Zhao guo, Jiang xin 2008). Ханзны заах аргын тал дээр маш олон судалгаа байх ба Wan yeyu (2005) –ийн ханзны хэрэглээний судалгаа нь харьцангуй төлөөлөх шинжтэй судалгаа байдаг. Ханзны сургалт нь дараах асуудлыг хөнддөг:

1. Ханз үсгийг яаж заах вэ? Хятад шиг сурах бичгээр заах уу эсвэл дотоод зүй тогтлыг нь заах уу?
2. Ханзны болоод галиг үсгийн соёлтой суралцагчдын хувьд ямар бодлогоор яаж заах вэ?
3. Ханзны сургалтын дэс дараалал нь энгийнээс хүнд рүү байх уу эсвэл өндөр давтамжаас бага давтамжаар заах уу? “谢” бол өндөр давтамжтай үг гэхдээ хялбар биш, “已、页、刀、尺” хялбар боловч түгээмэл хэрэглэдэггүй.
4. Ханз үсгийг заахдаа үг бүтэх аргыг ярих уу ярихгүй юу? Дүрс дуурайсан үсгийг заахад амар байхад бусад аргыг заахад хүндрэлтэй. Өөр өөр соёлтой хүмүүс өөрийн гэсэн ойлгоцтой байна. “安” гэсэн ханз нь нэг дээвэр, нэг бүсгүйгээс бүтнэ. Өрөөн доторх эмэгтэй гэсэн утгаар ойлгон “安全”，“安心” гэж тааварлаж болно. Гэтэл манай европ суралцагч маань “麻烦” гэж ойлгосон юм.
5. Зарим нэг утга уран зохиолын шинжтэй үг хэллэгийг анхан шатны ханз

үсгийн сургалтын үед хэрэглэвэл суралцагчдад тус дөхөм болдог. Жишээ нь “和谐” -ийн “和” -ийг “有饭吃，有言论自由，就会和谐” гэж тайлбарлавал өөрийн санаагаар тайлбарласан болно. Хэрхэн яаж тайлбарлах нь бас л бодож үзүүштэй.

6. Ханз үсэг нь тогтолцоо бүхий бүтэцтэй тул сургалтын явцад энэхүү тогтолцоог эзэмшүүлсэнээр суралцагч нь тухайн сурсан зүйлийнхээ үндсэн дээр бусад зүйлийг таамаглан мэдэж авах боломжтой. Сурах бичиг хийхдээ ханз үсгийн тогтолцоот шинжийг бодолцох нь чухал.
7. Ханз үсэг хэрэглэгдэх давтамжийн асуудал. Сургалтын явцад шинэ үсгийн илрэх давтамжийг бодолцох хэрэгтэй, хэтэрхий цөөн бол суралцагчид цээжилж тогтоохгүй, хэтэрхий олон бол сургалтын үр дүнд нөлөөлдөг. Үүнийг мөн адил туршилтын тоо баримтын тусламжтайгаар суралцагчдын танин мэдэхүй үйл явц, танин мэдэхүй зүй тогтлыг эзэмшүүлснээр сурах бичгээ боловсруулах нь зүйтэй.

3.5 Үгийн хэрэглээний тухай

Хоёрдагч хэлний сургалт нь ач холбогдолтой, бас сонирхолтой ажил юм. Сургалтын явцад суралцагчид бид бүхэнд маш үнэтэй асуултуудыг өгдөг бөгөөд тэдгээр асуултыг бид бодож, судалдаг. Нэгэн удаа манай Mauritius-ийн оюутан гэрт маань ирээд “老师，你媳妇不在家吗？” гэж асуусан. Энэ бол маш нийтлэг гаргадаг алдаа. “媳妇” -ийн утга нь эхнэр боловч ямар үед, ямар нөхцөлд, ямар газар, яаж хэрэглэх зарчим байдаг. Зөв оновчтой өгүүлбэр зохиож сурахын хажуугаар яаж хэлбэл илүү зүй зохистой байх талаар заах сургах нь зүйтэй. Хэлний хэрэглээнд хамтын зарчим болон боловсон байх зарчмыг мөрдөх хэрэгтэй. Эс бөгөөс харилцааны ёс зүйн зарчмыг эвдэх болно. Хятад хэл хэлзүйн хувьд хүндэтгэл байхгүй боловч хүндэтгэл илэрхийлсэн үгийн сангийн аргаар маш баялаг. Дараах харилцан яриа бол суралцагч, багш хооронд өрнөсөн юм.

14. 学生：老师很会讲课，能说会道，讲得天花乱坠。

老师：你会用成语这很好，但是……

学生：老师不要拍马屁。

Үгийн хэрэглээний асуудалд харилцааны ур чадвар, бодлого багтдаг (Cui xiliang 1992a, 1992c). Өөр өөр орны суралцагчид эх хэлнийхээ харилцааны зарчмаар дамжуулан хятад хэлээр харилцдаг нь зарим үед амжилтгүй болдог. Тухайлбал хятад хэлэнд төрөл садны нэршлийг хөрш, цаашилбал танихгүй хүн дээр хүртэл хэрэглэдэг нь европ америкийн суралцагчид хэрэглэж заншдаггүй. Метро дотор нэгэн гадаад оюутан, бяцхан охинтой танилцахад ээж нь охиндоо “Эгчээ гэж дуудаарай” гэхэд тэр оюутан “Намайг Анна гэдэг, Анна гэж дууд” гэж хэлсэн. Тэр оюутан надтай танилцсанахаа дараа ч бас намайг байнга нэрээр минь дууддаг,

энэ нь нэгэн төрлийн дотно байгаагаа илэрхийлж буй хэлбэр боловч хятад хэлэнд энэ нь тохиромжгүй байдаг.

Сургалтын чанар, үг өгөөжийг хэрхэн сайжруулах асуудал нь сургалтанд тулгарч буй хэрэглээний асуудал гэхэд болно. Үүнд: сургалтын хэлний хүчин зүйлийн судалгаа, аливаа хэлний заах аргын бодит судалгаа, заах аргын хэлбэрийн судалгаа, хэлний харьцуулсан судалгаа, нийтлэл болон тусгай шинжит судалгаа, хэлний хүчин зүйлд чиглэсэн заах аргын судалгаа, суралцагчид суурилсан заах аргын судалгаа, сургалтын орчинд чиглэсэн сургалтын материалын судалгаа, бодит танхим болон дуураймал танхмын сургалтын судалгаа гэх зэрэг.

4. Хятад хэлний багшийн эрдэм шинжилгээний өөрийн ухамсарт юу багтах вэ
Дээрх сэдвийн хүрээнд бид бүхэн дараах хэдэн зүйл багтана гэж бодож байна. 1-рт: хятад хэлний багшийн онолын өөрийн ухамсар, 2-рт: хятад хэлний багшийн асуудлын ухамсар, 3-рт: хятад хэлний багшийн эрдэм шинжилгээ хийх өөрийн ухамсар.

4.1 Хятад хэлний багшийн асуудлын ухамсар

Эрдэм шинжилгээний ажил бичих өөрийн ухамсар нь асуудлаа хэрхэн ойлгож ухамсарласнаас эхлэнэ. Бидний сургалт, өдөр тутмын амьдарлын явцад маш олон асуудал тулгардаг ба хүмүүс наргиа болгож өнгөрдөг байхад зарим хүн бясалгаж байдаг. Жишээ нь:

15. 冬天, 能穿多少穿多少(a); 夏天, 能穿多少穿多少(b)。

成为剩女的原因有两个: 一是谁都看不上(a); 二是谁都看不上(b)。

Дээрх 2 өгүүлбэр дэх (a), (b) гэсэн хэсгийн хэлбэрүүд адил боловч утгын хувьд өөр юм. Ийм үзэгдэл яагаад гарах болов? Хятад хүмүүс ойлгож болох боловч гадаад хүмүүс үүнийг ойлгоход бэрх байна. Бид бүхэн энэ асуудлыг судлан ялгаа гарч буй нөхцлийг нь тодруулах ёстой. Асуудлаа ухамсарлаж чадаж байвал нэлээд асуудлыг судалж болно. Судлах явцдаа бид бүхэн бусдын хийсэн холбогдох судалгааны материалыг харж, түүн дотроос зүй тогтолыг нь илрүүлэн онолыг нэгтгэн гаргаж болно. Тиймээс бид бүхэн хятад багшийн судлуулттай дараах хэдэн зүйлийг санал болгон дэвшүүлж байна.

1. Заах арга, сургалтын явцад нэлээд олон асуудлыг олж харж болно. Заах аргын туршлагагүй хүн ийм асуудлыг санахгүй. Тухайлбал: хэрвээ гадаад суралцагч “丫头” гэсэн үгийн утгыг мэдэхгүй юу гэсэн үг вэ? “X头” гэж байдаг уу гэж асууж болно. “丫头” гэдэг нь чинээлэг айлын зарц бүсгүй болохыг мэдээд “Улаан асрын зүүд” зохиолын Feng эгчийг яагаад “凤丫头” гэж дууддаг вэ? Иймэрхүү асуултаас багш бид бүгд бултах аргагүй байдаг.
2. Олон олон асуудлууд хэрэглээний ном болон судалгааны үр дүнгээс бодит тодорхой хариулт болж чадахгүй байна. Гагцхүү бид бүхэн өөрсдөө судлах

зүйлүүд байна.

3. Зарим нэгэн асуудал хятад хэлний хэл шинжлэлийн хүрээнд судалгааны ололт амжилттай байна. Тухайлбал “把” үсэгт өгүүлбэр, 被动句. Гэвч эдгээр ололт амжилтыг заах арга, сургалтын агуулгад шилжүүлэх тал дээр багш нар маань бодитой зүйл хиймээр байна.
4. Судалгааны ололт амжилтыг сургалтын практик, туршлагаас олж авдаг тул бусад хүн тухайн асуудлын талаар судлах арга байдаггүй.

4.2 Хятад хэлний багш нарын онолын талаарх ойлголт

Хэл шинжлэлийн онол, хэлний сургалтын онол, хэл сурах онол, хэлний чадвар ба туршилтын онол гэх зэрэг асуудлыг бид бүхэн судалснаар судалгааныхаа хүрээгээ баяжуулан дээд шат хүртэл авч үзэн дэлхийн бусад орны судлаачидтай харилцах хэрэгтэй байна. Эрдэм шинжилгээний ойлголт нь онолыг хэр эзэмшсэн байдлаас хамаарна. Онол байна гэдэг судлах сэдэвтэй байна гэсэн үг бөгөөд ямар шинж чанарын асуудалд багтаж болох, бусад асуудалтай ямар холбоо хамааралтай болох, тэдгээрийн арга хэрэгсэл юу болох, ямар бэрхшээл байгаа талаар улам илүү тодруулж болно. Хоосон зүйлээс онол бий болно гэж байхгүй бөгөөд аливаа онол өөрийн гэсэн гүн ухаан, түүхийн үндэслэлтэй байдаг гэдгийн мэддэг байх хэрэгтэй. Бидний мэддэг хэл шинжлэлийн онол, хэлний сургалтын онол, хэл заах онол бүгд баруунаас гаралтай ба хятад хэлний үзэгдлийг тайлбарлах үед зарим тохиолдолд аргаа олж чаддаггүй. Тиймээс хятад хэлний бодит байдал нийцсэн хэл шинжлэлийн онол бий болгохыг хүсдэг.

4.3 Хятад хэлний багшийн эрдэм шинжилгээний бүтээл төрөхүй

Хятад хэлний багш нь сайн багш байхаас гадна сайн судлаач байх хэрэгтэй. Энэ 2 шаардлага огт адилгүй юм. Хятад хэлний багш нь дараах 2 төлөвлөгөөг хийх ёстой гэж үздэг. 1. Мэргэжлийн карьераа төлөвлөх, 2. Эрдэм шинжилгээ, судалгааны карьераа төлөвлөх.

4.3.1 Мэргэжлийн карьераа төлөвлөх

Урьд нь хүмүүс гадаад хүнд хятад хэл заана гэдэг нь эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн агуулга ерөөсөө багтаах шаардлагагүй нэн хялбар ажил гэж үздэг байсан. Энэхүү үзэгдэл нь ор мөргүй байхгүй болсон гэж хэлэхгүй ч гэсэн харьцангуй багассан гэж бодож байна. Хятад хэлний багш мэргэжлийн үүднээс тусгай хэрэгцээт мэргэжил гэсэн үүднээс хандан мэргэлийн төлөвлөгөөг сайн хийх хэрэгтэй. Дэлхийн аль ч улс оронд сургалт явуулж байж болох тул мэргэжлээ хүндэлж, бахархаж байхаас гадна сэтгэл зүйн бэлтгэл, дасан зохицох чадвартай байх хэрэгтэй. Мэргэжлээсээ гадна хятадын кунфү, тайжичуань, хятад хоол зэргийг хийх чадвартай байх.

4.3.2 Эрдэм шинжилгээ, судалгааны карьераа төлөвлөх

Судлаач байна гэдэг хэцүү биш ч гэсэн энэ талын хүсэл эрмэлзэл, сонирхол тэмүүлэлтэй байхаас гадна мэргэжлийн хэрэгцээ шаардалага байх ёстой. Хятад хэлний багш нь судалгааны төлөвлөлтийг сайн хийх нь чухал. 1. Өөрийн сониуч занг төлөвшүүлэх. Асуудал бүртэй тулгарах бүртээ яагаад гэж асууж байх. 2. Өөртөө тохирсон судалгааны чиглэлийг эрэлхийлэх. Тухайн судалгааны чиглэл дээрээ бат тууштай зогсож, үнэнч шударга хандаж, хэрэгжүүлдэг байх. 3. Олон олон багш өөрийн мэргэжилдээ гарамгай, өөрийн мэргэжил, ажил хоёрыг уялдуулж бүтээлч байдлаар ажилдаа ханддаг байх. 4. Мэдлэг хуримтлуулахын хэрээр түүний цаад утга санаа, зүй тогтлыг ухаж ойлгох хэрэгтэй. Ингэснээр өөрийн гэсэн онолыг бий болгох. Хангалттай их мэдлэгтэй байж болох боловч цаад утга санаа, агуулгыг ойлгохгүй байвал ямар ч үнэ цэнэгүй байх болно.

Ашигласан материал

Chen chen (2010a) Англи хэлтэй суралцагч хэл найруулгын холбох тал дээр гаргадаг түгээмэл алдаа, Бээжин, Бээжингийн их сургууль хэвлэлийн хороо

Chen chen (2010b) Англи хэлтэй суралцагч дээд шатны хятад хэлний хэл найруулгын холбох тал дээр гаргадаг түгээмэл алдаа, Бээжин, Бээжингийн их сургууль хэвлэлийн хороо

Chen feng (2010) Гадаад суралцагчдад хятад хэл заах арга, Бээжин, Хятад номын хороо

Cui xiliang (1991) Зэрэгцсэн бүтэцтэй хос дуудлагатай үгийн бүтцийн загвар, Бээжин, Бээжингийн хэлний коллежийн хэвлэлийн газар

Cui xiliang (1992a) Хэлний харилцааны чадвар ба харилцан ярианы агуулга, Хэл заах ба судалгаа, 2-р хэвлэл

Cui xiliang (1992b) Биеийн төлөөний үг нэр үгийг тодотгодог “的” -ийн далд асуудалд, Дэлхийн хятад хэлний заах арга, 3-р хэвлэл

Cui xiliang (1992c) Хэл ярианы тайзны үг ба харилцах бодлого, Найруулга зүйд сурахуй, 4-р хэвлэл

Cui xiliang (2000) Япон суралцагч хятад хэл сурах болон хятадын соёлыг ойлгохуй, 21-р зуун ба боловсролын өөрчлөлт, Токио

Cui xiliang (2003) Онолын хэлзүй ба сургалтын хэлзүйн зангилааны талаар өгүүлэхүй, Хонгконг, Хонгконгийн боловсролын коллежийн хэвлэлийн газар

Cui xiliang (2007) Хятад хэлний багшийн мэдлэг ба чадвар, Бээжин, Шанү хэвлэлийн газар

Cui xiliang (2009) Хэл шинжлэлийн удиртгал, Бээжин, Шанү хэвлэлийн газар

Cui xiliang (2010a) Хятад хэлний олон улсын боловсрол “3 заах” асуудлын цөм ба

суурь, Дэлхийн хятад хэлний заах арга зүй, 1-р хэвлэл

Cui xiliang (2010b) Европ, америкийн суралцагч хятад хэлний угтвар үг сурах онцлог, алдаанд хийсэн анализ, Бээжин, Бээжингийн их сургуулийн хэвлэлийн газар

Cui xiliang (2011) Асуудлаас онол уу, онолоос асуудал уу, Хятад хэлний олон улсын нэвтрүүлгийн судалгаа, Бээжин, Шанү хэвлэлийн газар

Feng xiaoding (2003) Богино хугацааны гадаад суралцагчдын сэдэлд хийсэн судалгаа, анализ, Юннаны багшийн их сургуулийн сонин, 2-р хэвлэл

Feng xue (2010) Хятад хэлний сургалтагд хятадын соёлыг нэвтрүүлэхүй, Фүдан их сургуулийн магистрын зэрэг горилсон диплом

Gao yande (1993) Гадаад хүн хятад хэл сурч буй нөхцөл байдал хийсэн судалгааны тайлан, Бээжин, Бээжингийн хэлний коллежийн хэвлэлийн газар

Jiang liping (2008) Гадаад суралцагчдад хятад хэл заах сургалтын онол, Бээжин, Бээжингийн хэлний коллежийн хэвлэлийн газар

Li juan (2007) Үүргийн бүтцэт заах арга ба ЗР заах аргын онолын үндэслэл ба загварын харьцуулал, Шаньси боловсролын коллежийн сонин, 3-р хэвлэл

Lu bisong (1992) Гадаад суралцагчдад хятад хэл заах удиртгал, Дэлхийн хятад хэлний заах аргазүй, 2-р хэвлэл

Qian xunqing (1999) Гадаад суралцагч хятад хэл сурах үеийн шаналал, Хэл заах ба судалгаа, 2-р хэвлэл

Shao jingmin (2011) Шинэ үеийн хятад хэлний хэлзүйн түүх, Бээжин, Шанү хэвлэлийн газар

Shi renjuan (2005) Гадаад суралцагч хятад хэл сурах зовнилын нөхцөл байдал, даван туулах хэлбэрт хийсэн судалгаа, Хуадуны багшийн их сургуулийн магистрын зэрэг горилсон дипломын ажил

Wan yeyu (2005) Хэрэглээний ханз үсэг судлалын тухай, Хэфэй, Анхуй их сургуулийн хэвлэлийн газар

Wang xinjia (2008) Хятад хэлний авианы судалгаа ба хятад хэлний авиазүйд тулгарч буй асуудал, Бээжин, Бээжингийн их сургуулийн хэвлэлийн газар

Wang zhigang (2004) Гадаад суралцагчид хятад хэл сурах зорилгод хийсэн судалгаа, Дэлхийн хятад хэлний заах аргазүй, 3-р хэвлэл

Wei chunmu (1992) Суурь хятад хэлний сургалтын үеийн соёлын агуулгыг өгүүлэхүй, Дэлхийн хятад хэлний заах аргазүй, 1-р хэвлэл

Wu yongyi (20012) Гадаад суралцагчдад хятад хэл заах аргазүй, Бээжин, Шанү хэвлэлийн газар

Xie lingling (2012) Соёл төвт АНУ-ын хятад хэлний сургалтын загварын талаар өгүүлэхүй, Хуажун багшийн их сургуулийн докторын дипломын ажил

Xu qiuhan (2008) БНХАУ-д ирж суралцагчдын хятад хэл сурах сэдэлд хийсэн судалгаа, Бээжин, Бээжингийн хэлний их сургуулийн хэвлэлийн газар

Zhang bin (2010) ОЦХХ-ний дүрслэлийн хэлзүй, Бээжин, Шанү хэвлэлийн газар

Zhang li (2001) Гадаад суралцагчид хятад хэл сурах зовнил ба чөлөөтэй хаилцах байдалд хийсэн судалгаа, Хэл бичгийн хэрэглээ, 3-р хэвлэл

Zhang li (2002) Гадаад суралцагчид хятад хэлээр унших зовнилд хийсэн судалгаа, Хэл бичгийн хэрэглээ, 4-р хэвлэл

Zhang li (2002) Гадаад суралцагчдын зовнил ба дүнтэй холбогдох байдалд хийсэн дүн шинжилгээ ба сургалтын бодлого, Хэл заах ба судалгаа, 1-р хэвлэл

Zhang min (1998) Танин мэдэхүйн хэл шинжлэл ба хятад хэлний нэр үгийн холбоо үг, Бээжин, Хятадын нийгэм шинжлэх ухааны хэвлэлийн газар

Zhao guo (2008) Ханзны сургалтанд ямар бодлого хамгийн үр дүнтэй вэ? Бээжин, Бээжингийн их сургуулийн хэвлэлийн газар

Zhao shenzhou (1989) Соёлын ялгаа ба соёл хөтлөхүй талаар товч өгүүлэхүй, Хэл заах ба судалгаа, 1-р хэвлэл

Zheng yanqun (2008) Мэдээлэл харилцааны технологи ба дэлхийн хятад хэлний заах арга, Бээжин, Гадаад хэлний сургалт, судалгааны хэвлэлийн газар

Zheng yanqun (2009) Хятад хэлний мультмедиа сургалтад PPT хийх нь, Бээжин, Бээжингийн хэлний их сургуулийн хэвлэлийн газар